



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/192

Сүхбаатар сум

Маягтын загвар батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.1.17, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 15 дугаар зүйлийн 15.4.1, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 301 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн байгууллагуудад мөрдөх төрийн албан хаагчийн албан томилолтын маягтыг нэгдүгээр хавсралтаар, замын хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, зам хоног, уналгын зардлын төсвийг тухай бүр баталсны үндсэн дээр олгох ба шаардлагагүй тохиолдолд төрийн албан хаагчид байрны зардал төсөвлөн олгохгүй байх, батлагдсан төсөвтөө багтаан ажиллахыг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт зөвлөсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Мөнхбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш ОРГИЛ

Аймгийн Засаг даргын 2020 оны 07-р сарын 09-ны А/1192 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



БАЙГУУЛЛАГЫН НЭР

**АЛБАН ТОМИЛОЛТЫН
ҮНЭМЛЭХ**

Сум

2020 он

Утга нь	Олговол зохих	Олгосон урьдчилгаа
Зам хоног		
Ор хоног		
Уналгын зардал		
ДҮН		
Олгох		

Томилолтыг _____хоногоор сунгав.

ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Томилолтоор ажилласан _____/ажилтай/ _____

Аймгийн Засаг даргын 2020 оны
07-р сарын 09-ны /112/ тоот
захирамжийн хоёрдугаар хавсралт

ДАРГА
(гарын үсэг)

БАТЛАВ
ОВОГ НЭР

ЗАМЫН ХУУДАС

Огноо _____ сум

1. Маршрут _____ км

Нийт _____ км

Маршрут зохиосон:

Жолоочийн нэр /Автомашины дугаар/